



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/81/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Ч.Ариунаа Утас: 7052-3020 Цахим хаяг: Ariunaach@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ТГТ	Төсвийн Гүйцэтгэлийн Тайлан
ОНТ	Орон Нутгийн Төсөв
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МГТ	Мөнгөн Гүйлгээний Тайлан
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1.Ерөнхий зүйл	12
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4.Материаллаг байдал	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7.Шилэн дансны мэдээлэл	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9.Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4.Менежментийн захидал	19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

САЙХАНДУЛААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ГАНБАТ ТАНАА

Ауд. 02.24 № 16/90
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын дарга 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,549,819.00	28,115,265.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	6,025,370.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	52,516.77
335	Бусад авлага	-	5,972,854.00
3351	Байгууллагаас авах авлага	-	5,972,854.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,549,819.00	22,089,895.00
354	Хангамжийн материал	22,549,819.00	22,089,895.00
35410	Бичиг хэргийн материал	1,715,864.00	2,238,060.00
35420	Аж ахуйн материал	10,075,885.00	10,371,885.00
35440	Түлш, шатах тослох материал	4,595,670.00	6,253,050.00
35470	Бусад хангамжийн материал	6,162,400.00	3,226,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,376,189,688.77	1,481,266,964.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,376,189,688.77	1,481,266,964.39
392	Биет хөрөнгө	1,355,297,788.79	1,458,725,564.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	690,795,534.55	892,484,583.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,961,142.28)	(24,128,534.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	225,484,700.00	226,229,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,647,881.79)	(28,737,040.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,485,470.01	115,528,634.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,204,803.89)	(34,910,932.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,294,615.00	38,089,615.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,163,099.22)	(30,863,502.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	464,969,390.50	497,575,782.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(193,762,125.09)	(192,577,742.23)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	114,972,131.00	-
39217	Ном	35,000.00	35,000.00
393	Биет бус хөрөнгө	20,891,899.98	22,541,399.96
39301	Програм хангамж	1,163,800.00	2,890,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(390,100.02)	(467,600.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,578,200.00	20,578,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(460,000.00)	(460,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,398,739,507.77	1,509,382,230.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,398,739,507.77	1,509,382,230.16
51	Засгийн газрын хувь оролцоо	1,398,739,507.77	1,509,382,230.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	552,882,366.47	552,882,366.47
51101	Өмч: - төрийн	552,882,366.47	552,882,366.47
512	Хуримтлагдсан үр дүн	487,159,734.36	597,802,456.75
51210	Өмнөх үеийн үр дүн	487,159,734.36	487,159,734.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	110,642,722.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	358,697,406.94	358,697,406.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,398,739,507.77	1,509,382,230.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	542,510,542.00	545,752,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,704,685.00	195,925,171.00
120	Нийтлэг татварын бус орлого	129,704,685.00	195,925,171.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	129,704,685.00	505,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	505,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	129,011,035.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		195,170,171.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ		250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,805,857.00	349,826,979.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275,869,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275,869,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,963,926.00	48,484,479.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,984,479.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,963,926.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	124,972,131.00	301,342,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	301,342,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	332,529,892.46	380,714,928.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,529,892.46	380,714,928.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,546,287.07	374,968,145.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,332,644.61	212,560,639.07
210101	Үндсэн цалин	193,332,644.61	212,560,639.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,276,000.00	27,203,683.23
210201	Тэтгэврийн даатгал	15,827,600.00	18,534,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,862,100.00	2,180,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,700.00	1,691,883.23
210204	Ажилгүйдлийн даатгал	372,400.00	436,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,724,200.00	4,361,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,080,140.00	10,176,269.00
210301	Гэрэл, цахилгаан	1,610,300.00	1,917,435.00
210302	Түлш, халаалт	7,369,840.00	8,168,834.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	90,000.00

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	27,608,238.24	17,024,319.00
210401	Бичиг хэрэг	4,135,256.00	3,892,554.00
210402	Тээвэр, шатахуун	17,130,979.00	9,630,817.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,649,820.00	1,982,848.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,132,750.00	706,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,928,528.24	811,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	630,905.00	-
2105	Нормативт зардал	363,700.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	363,700.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,936,240.00	5,247,500.00
210604	Урсгал засвар	2,936,240.00	5,247,500.00
2107	Томилолт, зочны зардал	9,895,258.00	2,237,400.00
210702	Дотоод албан томилолт	9,895,258.00	2,237,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,488,708.00	49,423,489.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,053,000.00	48,164,958.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	203,500.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	734,800.00	500,885.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	417,408.00	439,646.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,565,358.22	50,294,845.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,131,111.00	8,973,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	580,000.00	862,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,854,247.22	40,458,395.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,983,605.39	5,746,782.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	754,000.00	1,076,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	754,000.00	1,076,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,172,605.39	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,172,605.39	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	57,000.00	4,670,782.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,000.00	4,670,782.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	209,980,649.54	165,037,221.78
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	54,394,499.39
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	54,394,499.39
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(54,394,499.39)

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	209,980,649.54	110,642,722.39
---	-------------------------	----------------	----------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	288,527,376.00	350,331,979.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	693,650.00	505,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	693,650.00	505,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	693,650.00	505,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	693,650.00	-
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	505,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	287,833,726.00	349,826,979.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275,869,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275,869,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,963,926.00	48,484,479.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,984,479.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,963,926.00	500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	301,342,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	301,342,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	287,377,376.00	345,931,979.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,377,376.00	345,931,979.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,347,770.61	334,212,342.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,260,284.61	212,560,639.07
210101	Үндсэн цалин	193,260,284.61	212,560,639.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,276,000.00	27,256,200.00
210201	Тэтгэврийн даатгал	15,827,600.00	18,534,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,862,100.00	2,180,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,489,700.00	1,744,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	372,400.00	436,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,724,200.00	4,361,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,136,460.00	10,151,342.00
210301	Гэрэл, цахилгаан	1,610,300.00	1,882,178.00

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	8,426,160.00	8,179,164.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	90,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,964,320.00	18,493,148.00
210401	Бичиг хэрэг	3,586,400.00	3,960,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,896,500.00	10,480,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,674,320.00	2,719,648.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	357,100.00	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	450,000.00	983,200.00
2105	Нормативт зардал	200,000.00	1,810,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,010,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,579,990.00	3,080,000.00
210604	Урсгал засвар	1,579,990.00	3,080,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,895,258.00	2,237,400.00
210702	Дотоод албан томилолт	9,895,258.00	2,237,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,759,058.00	42,819,406.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,323,350.00	41,560,875.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	203,500.00	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	734,800.00	500,885.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	417,408.00	439,646.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,276,400.00	15,804,207.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,976,400.00	14,804,207.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,029,605.39	11,719,636.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	1,076,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,076,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,172,605.39	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,172,605.39	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	57,000.00	10,643,636.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,000.00	4,670,782.93
213404	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,972,854.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,150,000.00	4,400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,150,000.00	4,400,000.00

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,150,000.00	4,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,150,000.00	4,400,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	3,000,000.00
223001	Бусад хөрөнгө	1,150,000.00	1,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,150,000.00)	(4,400,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	289,819,084.86	1,201,398,858.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	289,819,084.86	1,201,398,858.27
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	197,340,649.50	197,340,649.50
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	487,159,734.36	1,398,739,507.77
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	487,159,734.36	1,398,739,507.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	487,159,734.36	1,398,739,507.77
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	110,642,722.39	110,642,722.39
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	552,882,366.47	358,697,406.94	597,802,456.75	1,509,382,230.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304,115,900.00	301,847,500.00	2,268,400.00	99.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,115,900.00	301,847,500.00	2,268,400.00	99.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,015,900.00	296,100,717.07	6,915,182.93	97.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,049,700.00	212,560,639.07	5,489,060.93	97.48
210101	Үндсэн цалин	218,049,700.00	212,560,639.07	5,489,060.93	97.48

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,256,200.00	27,256,200.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	18,534,200.00	18,534,200.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,180,500.00	2,180,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,744,400.00	1,744,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	436,100.00	436,100.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,361,000.00	4,361,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,210,300.00	10,151,342.00	58,958.00	99.42
210301	Гэрэл, цахилгаан	1,610,300.00	1,882,178.00	(271,878.00)	116.88
210302	Түлш, халаалт	8,500,000.00	8,179,164.00	320,836.00	96.23
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	90,000.00	10,000.00	90.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,467,700.00	17,317,148.00	150,552.00	99.14
210401	Бичиг хэрэг	3,244,300.00	3,230,200.00	14,100.00	99.57
210402	Тээвэр, шатахуун	10,162,900.00	10,162,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,500.00	2,590,848.00	109,652.00	95.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	350,000.00	10,000.00	97.22
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	983,200.00	16,800.00	98.32
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,480,000.00	7,480,000.00	-	100.00
210602	Тавилга	4,400,000.00	4,400,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	3,080,000.00	3,080,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,677,200.00	1,647,400.00	29,800.00	98.22
210702	Дотоод албан томилолт	1,677,200.00	1,647,400.00	29,800.00	98.22
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,074,800.00	3,083,781.00	991,019.00	75.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,572,000.00	1,825,250.00	746,750.00	70.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	734,800.00	500,885.00	233,915.00	68.17
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	439,646.00	10,354.00	97.70
210805	Тээврийн хэрэгслийн оношилогоо	88,000.00	88,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,000,000.00	15,804,207.00	195,793.00	98.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,804,207.00	195,793.00	98.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,100,000.00	1,076,000.00	24,000.00	97.82

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,100,000.00	1,076,000.00	24,000.00	97.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100,000.00	1,076,000.00	24,000.00	97.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,670,782.93	(4,670,782.93)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	304,115,900.00	301,847,500.00	2,268,400.00	99.25
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	303,115,900.00	301,342,500.00	1,773,400.00	99.41
132001	Орон нутгийн төсвөөс	303,115,900.00	301,342,500.00	1,773,400.00	99.41
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	505,000.00	495,000.00	50.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	505,000.00	495,000.00	50.50
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	48,484,479.00	(48,484,479.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	48,484,479.00	(48,484,479.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	42,511,625.00	(42,511,625.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,176,000.00	(1,176,000.00)
210401	Бичиг хэрэг	-	730,000.00	(730,000.00)
210402	Тээвэр, шатахуун	-	317,200.00	(317,200.00)
2105	Нормативт зардал	-	1,010,000.00	(1,010,000.00)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,010,000.00	(1,010,000.00)
2107	Томилолт, зочны зардал	-	590,000.00	(590,000.00)
210702	Дотоод албан томилолт	-	590,000.00	(590,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	39,735,625.00	(39,735,625.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	39,735,625.00	(39,735,625.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,972,854.00	(5,972,854.00)
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,972,854.00	(5,972,854.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	48,484,479.00	(48,484,479.00)

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	48,484,479.00	(48,484,479.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	47,984,479.00	(47,984,479.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	500,000.00	(500,000.00)

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Ганбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.02.04-өөс 2021.02.08–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Ч.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Сайхандулаан сумын ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** 2021.01.22-ны өдрийн 3/48 дугаар бүхий албан бичгээр 2021.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Сайхандулаан сумын ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны ТГТ-ын тайлангийн батлагдсан төсвийн дүн 306,296.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,062.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчиллөө.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт зардал 435,109.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,351.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайхандулаан сумын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 110,642.7 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	6,025.4	6,025.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	22,549.8	22,089.9	-459.9
Үндсэн хөрөнгө	1,376,189.7	1,481,266.9	105,077.2
Нийт хөрөнгө	1,398,739.5	1,509,382.2	110,642.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,398,739.5	1,509,382.2	110,642.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,398,739.5	1,509,382.2	110,642.7

Авлага дансны үлдэгдэл 6,025.4 мянган төгрөг болж өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22,089.9 мянган төгрөг болж 459.9 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын үлдэгдэл нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,481,266.9 мянган төгрөг болж 105,077.2 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансанд ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 195,170.2 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,760.0 мянган төгрөг тус тус нэмэгдэж, 62,041.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,509,382.2 мянган төгрөг болж 110,642.7 төгрөгөөр өсөхөд үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Сайхандулаан сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,241.6 мянган төгрөгөөр өсөж 545,752.1 мянган төгрөг байна.

Нийт зардал өмнөх оноос 48,185.3 мянган төгрөгөөр буюу 0.14 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлсний зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 347,749.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 347,749.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43,633.2 мянган төгрөгөөр бууруулж 304,115.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 304,115.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 303,115.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 301,342.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 505.0 мянган төгрөг, нийт 341,847.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 297,176.7 мянган төгрөгийг зарцуулж 4,670.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 297,176.7 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь урсгал зардлыг 5,489.1 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 47,984.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 42,511.6 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 5,972.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, 147 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 43.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 311.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, бүрэн хэрэгжсэн байна. Аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	43.6	1	43.6	-		
Албан шаардлага	1	311.2	1	311.2	-		
Зөвлөмж	2	-	2	-	-		
Нийт дүн	8	12,972.9	8	12,972.9			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,676.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,565.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,629.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,482.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Сургалтын цайны материал, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал, хүүхдэд олгосон хүнсний материал зэргийг шууд зардалд бичсэн, зардлын тооцоо үүсгэлгүй шууд зардалд бүртгэсэн нийт 8,565.8 мянган төгрөгийн гүйлгээг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Бусад бараа үйлчилгээний зардлаас 400.0 мянган төгрөгийг томиллолт, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 466.0 мянган төгрөгийн аудитын үйлчилгээний төлбөр төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Цалингийн тооцоо үүсгэлгүйгээр НДШ, ХХОАТ-ын өглөг үүсгэх бичилт хийснээс даатгуулагчаас суутгасан НДШ-ийн өглөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас төлсөн

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,482.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

4.1.1 Илрүүлэлт:

Бусад биет бус хөрөнгө дансанд 460.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 программ хангамж бүртгэсэн

4.1.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол тус тус зөрчсөн байна.

4.1.3 Зөвлөмж

Бусад биет бус хөрөнгөд бүртгэлтэй байгаа 2 нэр төрлийн программыг биет бус хөрөнгийн программ хангамж дансанд шилжүүлэн бүртгэх

4.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

4.2.1 Илрүүлэлт

Түрээсийн орлогоос нийт 1570.0 мянган төгрөг төвлөрсөн бөгөөд МГТ-д 505.0 мянган төгрөгийн гүйлгээг тусгасан бөгөөд 1022.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг бууруулах гүйлгээ хийсэн байна.

4.2.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 2.14 дэх заалт тус тус зөрчсөн байна.

4.2.3 Зөвлөмж

Мөнгөн гүйлгээний тайланд орлого зарлагыг тайлагнаж байх.

4.3 Балансын данстай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт

Тайлант онд нийт 62,041.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна. Актлах, устгах шийдвэр гарсан байхад 29,886.8 мянган төгрөгийн хөрөнгийг устгаагүй байна.

4.3.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна АИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт тус тус зөрчсөн байна.

4.3.3 Зөвлөмж

Актлах, устгах шийдвэр гарсан үндсэн хөрөнгийг устгалын комисс томилон устгуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Сайхандулаан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

ДГА-2021/81/СТА-

Огноо:

Аудитын нэр:

Аудитын код:

2021 Шалгагдсан байгууллагын нэр:	Сайхандулаан сумын ЗДТГ Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бусад биет бус хөрөнгөд программ хангамж бүртгэсэн	460.0	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	Т.Ганбат Ц.Соёлчмаа
2	Бусад бараа үйлчилгээний зардлаас 400.0 мянган төгрөгийг томилолт, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 466.0 мянган төгрөгийн аудитын үйлчилгээний төлбөр төлсөн	866.0	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Ц.Соёлчмаа
3	Түрээсийн орлогоос нийт 1570.0 мянган төгрөг төвлөрсөн бөгөөд МГТ-д 505.0 мянган төгрөгийн гүйлгээг тусгасан бөгөөд 1022.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг бууруулах бичилт хийсэн байна.	1,022.0	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	Т.Ганбат Ц.Соёлчмаа
4	Цалингийн тооцоо үүсгэлгүйгээр НДШ, ХХОАТ-ын өглөг үүсгэх бичилт хийснээс даатгуулагчаас суутгасан НДШ-ийн өглөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас төлсөн	763.1	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Ц.Соёлчмаа
5	Тайлант онд нийт 62041.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна. Акталж устгах шийдвэр гарсан байхад 29886.8 мянган төгрөгийн хөрөнгийг устгасан устгалын акт байхгүй байна	-	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	Т.Ганбат Ц.Соёлчмаа
6	В30103 маягтад тусгасан зардлын тооцоо үүсгэлгүй шууд зардалд бичсэн гүйлгээг залруулсан	8,565.8	Залруулсан	Нягтлан бодогч	Ц.Соёлчмаа
ДҮН		11,676.9			